

ЭРХЭМ ЧАНАРЫН ЁС ЗҮЙН СЭРГЭЛТ: ЭЛИЗАБЕТ АНСКОМБЕГИЙН ‘ОРЧИН ҮЕИЙН ЁС СУРТАХУУНЫ ФИЛОСОФИ’-ИЙГ АВЧ ҮЗЭХ НЬ.

М.Отгонбаяр, доктор (Ph.D), профессор
МУИС-ийн Философи шашин судлалын тэнхимийн эрхлэгч
Э.Баасандорж, магистрант
МУИС-ийн Философи шашин судлалын тэнхим

Хураангуй: Элизабет Анскомбегийн ‘Орчин үеийн ёс суртахууны философи’ хэмээх бүтээл орчин үед эрхэм чанарын ёс зүйг сэргэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Үг өгүүллийн хүрээнд Анскомбе орчин үеийн ёс суртахууны философи, тэр дундаа үр дагаварчлах үзлийг хэрхэн шуумжилснийг тодруулах, өнөө үед эрхэм чанарын ёс зүйг хэрхэн авч үзэж буй тухайд тодруулахыг зорив.

Тулхүүр үг: эрхэм чанарын ёс зүй, ёс суртахуун, санаа зорилго, үл тайлбарлагдах баримт, үнэлэмж, зүй ёс, үр дагаварчлах үзэл, орчин үеийн ёс суртахууны философи.

Оршил

Эрхэм чанарын¹ ёс зүйн асуудлыг Платон, Аристотель нараас эхлээд стойкууд бас дундад зууны сэтгэгчид хөгжүүлж ирсэн байна. Грекийн *arkte* гэх үг хэлний *excellence* (давуу эсвэл гаргууд чанар) гэх үгтэй утга илүү дүйх боловч *virtue* гэх үгээр илэрхийлэх болжээ. *Arkte* бол ямарваа эд зүйл, амьтан эсвэл хүнд байх давуу чанаруудад хамаарах ойлголт юм. Энэ ойлголтыг хүмүүсийн ажил үүрэгтэй холбоотойгоор ихээхэн хэрэглэдэг байжээ. Жишээ нь сайн дайчны хувьд эрэлхэг, баатарлаг чанар нь *arkte* болох бол, дархан хүний хувьд гарын үр дүй нь *arkte* болох ажс.

Гомерын зохиолуудад баатарлаг чанар, эр зоригийг үг ойлголтой холбоотой ярьсан бол Платоны зохиолуудад илүү ёс суртахууны шинжстэй болжээ. Аристотелийн хувьд *arkte* гэдэг нь хот улсын сайн иргэн байхтай салигүй холбоотой бөгөөд зан байдлын гэгдэх эрхэм чанарууд нь аливаа хүнийг сайн иргэн байх, бас тухайн хүнийг хөгжин цэцэглэхэд зайлшигүй шаардлагатай чанарууд болдог ажээ. Стойкуудын хувьд эрхэм чанар бол хот улсаас үл хамааран, бүх хүнд, ертөнцийн оршин сууеч байхад нь шаардлагатай тийм чанарууд болдог. Харин Августин, Аквины Фома зэрэг дундад зууны сэтгэгчид үг ойлголтыг хайр, итгэл, найдвэр гэх мэт Христийн шашины ойлголтуудаар баяжуулсан байна. Эрхэм чанарын ёс зүй зөвхөн эртний болон дундад зууны үеийн өрнө дахины сэтгэлгээнд төдийгүй мөн дорно дахины сэтгэлгээнд ч байж ирснийг сүүлийн үед онцлох болов (*Angle, 2013*).

¹ Англи хэлний *virtue* гэх үгийт ийн буулгаж хэрэглэв. Өмнө Монгол хэлэнд энэ үгийт ‘сайн үйл’ эсвэл ‘буянт үйл’ гэх мэтээр орчуулж хэрэглэжээ. Гэхдээ *virtue* ethics хэмээх онолд гардаг *virtue* бол хүн өөртөө хөгжүүлж болдог, дадлын шинжтэй, сэтгэл мэдрэмж (*feeling*) хийгээд үйлдлийн хэв загварыг илтгэдэг. Иймд *virtue* бол тодорхой нэг үйлдэл биш харин хүнд байх зан чанар, үр чадварыг агуулдаг. Цаашлаад *virtues* гэдэг нь тийм хэв загваруудыг өрөнхийд нь биш, харин хүнийг тодорхой талаар гаргутуд бас давуу байгааг илтгэдэг, түүнчлэн хүндтэй амьдрах, аз жаргалтай амьдрахад эсвэл хөгжин цэцэглэхэд хэрэгтэй болдог тийм чанарууд бол. Иймд сайн үйл эсвэл буянт үйл хэмээх орчуулгаас тапталзаж, эрхэм чанар гэж оруулах нь илүү оновчтой хэмээн үзсэн. Англи хэлний *dignity* хэмээх үгийт эрхэм чанар хэмээн буулгаж занисан нь нэр томъёотой холбоотой дахин нэг хүндэр дагуулж байна. *Dignity* бол аливаа хүн хүн болохынхоо хувьд бусдад хүндлэгдэх, үнэлэгдэх заяамал эрхийг илтгэх ойлголт юм. Энэ бол хүнийн төрөхөөс нь хүндтэй болгож буй тийм чанар мөн. Иймд, үг өгүүллийн хүрээнд авч үзэж буй эрхэм чанар хэмээн үг нь *dignity* бус *virtue*-г илтгэж байгааг тэмдэглэе. Харин *dignity* хэмээх үгийг үнэт чанар хэмээн орчуулах нь зохижтой хэмээн үзэж байна.

Элизабет Анскомбэгийн 1958 онд нийтлүүлсэн *Орчин үеийн ёс суртахууны философи* хэмээх өгүүлэл эрхэм чанарын ёс зүй өнөө үед дахин сэргэх гол хөшүүрэг болсон юм. Анскомбе уг өгүүлэлдээ орчин үеийн ёс суртахууны философиид ноёлж ирсэн хоёр чиглэл болох деонтологи ба утилитари үзэлд хандсан шүүмжийг боловсруулж, сэтгэл судлалын философи хэмээн нэрлэсэн зүйлээ хөгжүүлэх санааг дэвшүүлсэн. Тэрээр сэтгэл судлалын философи гэх нэр томьёогоор яг юуг илэрхийлсэн нь тийм ч тодорхой биш боловч, санаа зорилго (intention), зан байдал (character), сэдэл (motive) зэрэгтэй холбоотой философи шинжилгээ үүнд багтаж байгаа нь түүний бүтээлүүдээс харагддаг.

Анскомбе ба орчин үеийн ёс суртахууны философи

Түүний *Орчин үеийн ёс суртахууны философи* өгүүлэл дараах гурван сэдвийг танилцуулснаар эхэлдэг:

Нэгдүгээрт, өнөө үед бидэнд ёс суртахууны философидолт ашиггүй; харин бид зохих сэтгэл судлалын философиийг хөгжүүлэх хүртлээ үүнийг хажуу тийш нь тавих хэрэгтэй бөгөөд сэтгэл судлалын философи бидэнд дутагдаж байгаа нь илэрхий байна. Хоёрдугаарт, алба үүрэг (obligation), үүрэг (duty)— ёс суртахууны алба үүрэг ба ёс суртахууны үүрэг— хийгээд ёс суртахууны хувьд буруу, зөвийн талаарх ойлголтууд, “ёстай” хэмээхийн ёс суртахууны утгыг, сэтгэл судлалын хувьд хэрэв боломжтой бол орхих учиртай; учир нь энэ ойлголтууд түрүү үеийн ёс зүйн талаарх ойлгооос үлдэж хоцорсон, тэрхүү үлдэж хоцорсон зүйлсээс урган гарсан зүйлс бөгөөд өнөө үед иймэрхүү үзэл ерөнхийдөө байхгүй бөгөөд бидэнд балаг авчрахаас

цаашгүй. Гуравдугаар сэдэв бол Сижвикээс эхлээд өнөө үе хүртэлх ёс суртахууны философиийн тухай авч үзсэн, алдартай Англи зохиогчдын дундах ялгаа тийм ч ач холбогдолтой биш тухайд болно.²

Анскомбе эдгээр сэдвийг боловсруулахдаа өнөө үеийн эрхэм чанарын философиодод түгээмэл ажиглагдах зарим гол санааны суурийг тавьсан гэж үзэж болох юм. Анскомбэгийн өгүүлэл түүний орчин үеийн хэмээн тодотгосон, Сижвик, Кант, Батлер, Милл гэх мэт сэтгэгчдийн ёс зүйн бүтээлийг Аристотелийн ёс зүйн бичвэртэй харьцуулж үзвэл эрс ялгаатай байдал гарч ирнэ гэдгийг дурдсанаар эхэлдэг. Орчин үеийн ёс суртахууны философиid танин мэдэхүйн ба ёс суртахууны гэх хоёр ойлголтыг хатуу ялган үздэг. Харин бид Аристотелийн бичвэрүүдэд хандах юм бол түүний танин мэдэхүйн гэж хэлж буй эрхэм чанар нь бас ёс суртахууны утгатай байдгийг олж харах боломжтой аж. Жишээ нь: Аристотель “ямар нэг машиныг тослох нь сайн” гэдэг бодомж бол зөвхөн танин мэдэхүйн ач холбогдолтой бөгөөд ёс суртахууны хувьд огтоос ач холбогдолгүй хэмээн үзэхгүй гэх санааг тэр илэрхийлжээ. Тодруулбал, уг машин машин болохынхoo хувьд сайн ажиллахад нь тос хэрэгтэй ажээ. Энэ нь хэлбэрийн хувьд хүний хөгжин цэцэглэлийн талаарх Аристотелийн баримтлалтай тун төстэй агуулгатай. Өөрөөр хэлбэл, аливаа хүн хүн болохынхoo хувьд хөгжин цэцэглэхэд эрхэм чанарууд хэрэгтэй гэдэгтэй ижил агуулга бүхий байна. Эндээс бид Анскомбе ёс зүйн шинжилгээнд баримтын агуулга бүхий ‘хэрэгтэй’ гэх ойлголт хэрэглэж болно хэмээн үзсэнийг харж болно. Гэхдээ түүний үзсэнээр ‘хэрэгтэй’ гэх энэ ойлголт “ёстай” гэх ойлголтой төстэй боловч орчин үеийн ёс суртахууны философиid ноёлж ирсэн “ёс суртахууны үүднээс ёстай” хэмээх өвөрмөц утга бүхий ойлголтоос ихээхэн ялгаатай болж таардаг.

² Anscombe. G.E.M. (1958) Modern Moral Philosophy, Journal Of Royal Institute of Philosophy, Vol 33. No 124. pp.1-19s.

Түүний шүүмжилсэн “ёс суртахууны” гэх ойлголтын орчин үеийн өвөрмөц утга нь Аристотель болон өнөө үе хоёрын дунд байсан Еврей-Христийн шашин дахь ёс зүйг хууль гэх үзлээс өнөө үлдэж хоцорсон зүйл аж. Ёс зүйг хууль гэх нь Еврей-Христийн шашин дахь ёс зүйн үзлийг дангаараа тодорхойлохгүй боловч үүний салшгүй нэг хэсэг мөн байсныг тэр бас дурдсан (Anscombe, 1958). Энэхүү үзэл нь “ёстай”, “алба үүрэгтэй” гэх мэт *ёс суртахууны өвөрмөц утга бүхий ойлголтуудаар дамжин ажилладаг*. Гэсэн ч Анскомбэгийн үзлээр ёс зүйг хууль гэх нь тэнгэрлэг хууль тогтоогчид итгэх итгэлгүйгээр ямар ч утгагүй бөгөөд ажиллах боломжоогүй аж. Түүний үгээр илэрхийлбэл ‘Гэмт хэргийн талаарх хууль ба эрүүгийн шүүхүүдийг татан буулгаж, эдгээр нь мартагдан үгүй болсон хойно ч “гэмт хэргэгтэн” гэх ухагдахуун үлдэх’ явдалтай ижил ажээ.³ Тэгэхээр ёс зүйг хуулийн шинжтэй гэх үзэл бол тэнгэрлэг хууль тогтоогч байдаг хэмээх итгэл үнэмшил бүхий хам сэдвийн хүрээнд л ажиллах боломжтой байтал орчин үеийн ёс суртахууны философичид тийм хууль тогтоогчид итгэхгүйгээр ёс зүйг хууль гэх үзлээ авч үлдэхээр зорьдог гэсэн үг юм. Ингээд Анскомбэгийн шүүмж дагуу тэд “ёстай” хэмээх ойлголтын сэтгэл хөдлөлийн нөлөө, санааг хадгалж үлдсэн хэдий ч утгыг нь үгүй хийжээ. Харин ёс зүйг хууль гэх үзлээс үлдэж хоцорсон, хоосон бөгөөд зөвхөн сэтгэл хөдлөлд нөлөөлөх ойлголтуутдай ноцолдох нь бидэнд балагт үр дагаврыг л авчрах ажээ.

Энэ сэдвийг лавшуулан үзвэл бид түүний баримт ба үнэлэмжийн заагт хандсан шүүмжийг харах боломжтой. Тэрээр Хьюмийн “бол”⁴ гэдгээс “ёстай” гэдгийг гарган авч чадахгүй тухайд хийсэн дүгнэлтийг нэлээд өндөрөөр үнэлсэн байна. Хьюм орчин үеийн ёс суртахууны философи дахь “ёстай” гэх

ойлголтын утгагүй байдлыг нээн илрүүлж, шүүмжилсэн явдал түүнийг гайхалтай софист (Anscombe, 1958) хэмээн үнэлэхэд хүргэсэн болов уу. Түүнийхээр Хьюм софист боловч, софист арга зүй дотроо үнэтэй нээлтүүдийг хийжээ.

“Ёстай” гэх үгийн ёс суртахууны өвөрмөц утгаас татгалзсан байдлаараа Анскомбе Хьюмтэй санал нэгдэж байна. Гэхдээ тэр Хьюмийн үзлээс урган гарсан эмотивизмийг хүлээн аваагүй бөгөөд өнөө үед бид “ёстай” гэх үгийн ёс суртахууны өвөрмөц утгад хандалгүйгээр зүй бус хүнийг муу хүн гэж үзэх, бас хүн зүй ёстой байх “хэргэгтэй” гэдгийг харуулах суурь хэрэгтэй тухайд үндэслэл дэвшүүлж байгаа нь түүний ёс суртахууны философийн талбар дахь реалист хандлагыг харуулна.⁵

Анскомбе “бол” гэдгээс “өртэй” түүнчлэн “бол” гэдгээс “хэргэгтэй” гэх мэт ойлголтууд руу шилжилт хийж болно, бас эдгээр нь “бол” гэдгээс “ёстай” (гэвч эн нь “ёс суртахууны үүднээс ёстай” гэх мөнөөх ухагдахуунтай ижил биш) гэдгийг гарган авахтай ижил юм гэж үзэхдээ, баримтын харьцангуй үл тайлбарлагдах чанар (relative bruteness of facts) хэмээх ойлголтыг ашигласан юм. Хэрэв бид Хьюмийг дагавал хүн өөрт нь хүнсний ногоо нийлүүлсэн хүнд мөнгө өгөх ёстой буюу өртэй гэдэг нь үнэн болохыг батлах аргагүй. Учир нь “ёстай” гэдэг бол үнэлэмжийн шинжтэй ойлголт бөгөөд үнэн бол үнэлэмжид биш зөвхөн санаануудын харилцаа эсвэл баримтад л хамаарах зүйл юм. Жишээ нь, үнэн гэдэг бол “Үнэн нь 20s = £1” гэх мэт санаануудын харилцаанаас, эсвэл би төмс захиалсан, чи түүнийг нийлүүлсэн, тэгээд над руу тооцооны баримтаяа явуулсан гэх мэт баримтаас тогтдог. Тэгэхээр үнэн гэдэг нь би ийм хэмжээний өртэй гэх хэллэгт хамаарахгүй. Над руу тооцооны мөнгө явуулсан гэдгээс би түүнд мөнгө өгөх ёстой буюу өртэй гэдэг дүгнэлт зайлшгүй урган гарахгүй. Харин Анскомбе үүнд дараах

³ Anscombe, G.E.M. (1958) Modern Moral Philosophy, Journal Of Royal Institute of Philosophy, Vol 33. No 124. p.10.

⁴ “is” хэмээх үтгийг “бол” хэмээн шууд буулгав.

⁵ Мөн тэнд. р.6.

хариуг өгсөн байна.

Хэрэв ийн харьцуулбал, “Х нь Y-д тийм хэмжээний өртэй” гэх тоочилтод дурдагдж буй баримтуудын харилцаа бидний сонирхлыг татах бөгөөд би үүнийг тухайн тоочилт “харьцангуйгаар үл тайлбарлагдах шинжтэй” (brute relative) байх явдал хэмээнэ. Цаашлаад, энд дурдсан “үл тайлбарлагдах” баримтуудад өөрсдөд нь өөр баримтуудад харьцангуйгаар “үл тайлбарлагдах шинжтэй” байх тоочилтууд бий — жишээ нь, тэр манай гэрт төмс зөөж авчирсан бас төмс тэндээ үлдсэн зэрэг нь “тэр надад төмс нийлүүлсэн” гэдэгт харьцангуй үл тайлбарлагдах баримт болох шиг. Бас X нь Y-д өртэй гэдэг нь эргээд өөр тоочилтуудад харьцангуй “Үл тайлбарлагдах шинжтэй” (brute) байна. — Жишээ нь, “Х нь төлбөрийн чадамжтай.” Ингэхлээр “харьцангуй үл тайлбарлагдах шинж”-ийн харилцаа нь төвөгтэй эд болж таарлаа. Цөөн хэдэн санаа дурдахад: хэрэв х, у, z гэдэг нь A тоочилтод харьцангуйгаар үл тайлбарлагдах баримтуудын олонлог бол, x, y, z нь A-г багтаадаг олонлогийн хүрээнээс гадна байх ямар нэг олонлог болно; гэвч эдгээрийн дунд ямар нэг олонлог багтах явдлаас A зайлшгүй байдлаар урган гарахгүй, учир нь онцгой тохиолдлууд дээрхийг өөрчлөх боломж ямагт бий; A-д харьцангуй байх онцгой тохиолдлууд ямар өөрчлөлт оруулж чадахыг цөөн хэдэн ялгаатай жишээ гаргаж тайлбарлах л боломж бий, ямар ч онцгой хам нөхцөлийг дахин тайлбарлах дараагийн онцгой хам нөхцөлийг онолын хувьд ямагт төсөөлж болох учраас, онцгой нөхцөл байдлыг онолын шинжтэйгээр урьдаас бүрэн тооцоолох арга үгүй. Түүгээр үл барам, жирийн нөхцөл байдалд ч, хуз нь A-ын зөвтгөл болно гэдэг бол A нь “хуз”-тэй зүгээр л ижил болж таарна гэсэн үг биш; бас тоочилт A-д утга санаагаа өгөх институцийн шинжтэй хам нөхцөл байх талтай бөгөөд, энд инститүц A нь өөрөө тоочилт байхгүй гэдэг нь мэдээж хэрэг юм. (Жишээ нь, би хэн нэг хүнд шиллинг өгсөн гэх бодомж бол энэ улсын мөнгөн дэвсгэрт эсвэл мөнгө гэдэг институцийн тоочилт биш юм.) Иймд, жишээ нь, “бол” гэдгээс “өртэй” гэдэгт чиглэсэн шилжилт огтоос байхгүй мэт дүр эсгэх нь инээдтэй хэрэг болох хэдий ч шилжилтийн онцлог шинж нь үнэн хэрэгтээ тун сонирхолтой бөгөөд Хьюмийн үндэслэлийг тунгаасны дунд ил болно.⁶

Үүнээс цааш тэр “Х нь Y-д өртэй” гэдэг нь нь “Х бол мэхлэгч” гэх тоочилтод харьцангуй үл тайлбарлагдах шинжтэй хэсэг бүлэг баримтуудын нэг болох тухай хэлдэг. Өөрөөр хэлбэл, тодорхой хам сэдвийн хүрээнд, хэсэг бүлэг баримт байгаа үед — жишээ нь: би тодорхой мөнгөн дунд тааруулж төмс захиалсан; нийлүүлэгч надад тэрхүү төмсийг авчирч өгсөн; тэр над руу төлбөрийн баримт илгээсэн; би үүнийг нь төлөөгүй — тэрхүү баримтуудаас “би мэхлэгч” гэдгийг мөрдөж болно. Гэхдээ энэ нь бүх нөхцөлд тийм байдаггүй. Учир нь мөнөөх баримтуудын олонлог дунд, намайг мэхлэгч болгохгүй байх өөр баримтууд орчихсон байж болно — жишээ нь: нийлүүлэгч маань надад муудаагүй төмс өгнө гэж амласан байсан ч авчирсан төмс нь муудчихсан байсан. Гэхдээ тийм биш буюу, жирийн нөхцөлд, өөрөөр хэлбэл төмс муудаагүй, эсвэл намайг мэхлэгч болгохгүй байх өөр баримтууд бүрдээгүй тийм нөхцөлд бол би мэхлэгч болж таарна. Харин “мэхлэгч” гэдэг бол зүй бус байдалд хамаарч болох ойлголт мөн. Иймд дээрх баримтуудаас би зүй бус хүн, наанадаж мэхлэгч нэгэн гэдэг нь гарч ирэх боломжтой байна. Ингээд Анскомбе баримтаас үнэлэмжийн эсвэл норматив шинжтэй ойлголт руу шилжилт хийх боломжийг гаргаж байна. Бас Анскомбэгийн сүүлд өгүүлж байгаачлан, бид зүй бус байж болохгүй бөгөөд дээрх шиг жирийн нөхцөлд би мөнгө өгөх хэрэгтэй; би мөнгө өгөх ёстой (энэ нь орчин үеийн ёс суртхууны хэмээх өвөрмөц утгын үүднээс биш гэдэг нь мэдээж) болж таарна.

Чухамдаа “бол” гэдгээс “ёстой” гэдэг рүү шилжих боломжид хандсан Хьюмийн шүүмж бол “ёстой” гэдгийн ёс суртхууны өвөрмөц утгад хандсан шүүмж болохоос Аристотельч үзэлд суурилсан утгат чанар бүхий “ёстой” хэмээх ойлголтод хандсан шилжилтэд нөлөөлөхгүй аж. Учир нь Аристотельч үүднээс хүний тодорхой зан чанар, зан

⁶ Anscombe. G.E.M. (1958) Modern Moral Philosophy, Journal Of Royal Institute of Philosophy, Vol 33. No 124. p.3.

байдалд холбогдох норматив ойлголт бүхий дүгнэмжийг гаргаж авч байгаа юм. ““Бол” гэдгээс ‘ёстай’ гэдгийг гарган авч болохгүй” хэмээх өгүүлбэр нь баримт ба үнэлэмжийн талаарх метафизик шинжтэй заагийн үүсэл байв. Харин Анскомбе дээрх үндэслэлээрээ баримт ба үнэлэмжийн талаарх тийм заагийг хэрэглэлгүйгээр ёс суртахууны бодомжуудад үнэний утга оноох боломжийг олгож байгаа юм.

Анскомбе бидэнд үнэлэмжийн шинжтэй бодомжууд хэрхэн рациональ байх боломжийг харуулж байгааг тодруулахын тулд түүний үр дагаварчлах үзэл (*consequentialism*)-д хандсан шүүмжийг авч үзье. Эндээс рационалиар үнэлж дүгнэх гэсэн, сэтгэл судлалын философиийг үл ашиглаж, зөвхөн үйлдлийн үр дагаврыг чухалчилж үзэх юм бол алдаа болно гэдгийг харуулах гэсэн түүний үндэслэлийг олж харна. Сижвикээс хойших Английн ёс суртахууны философичид сонгодог утилитари үзлээс үр дагаварчлах үзэл рүү шилжилт хийсэн хэмээн Анскомбе үзжээ. Чухам ингэснээр Английн академик ёс суртахууны онолчид аливаа үйлдэл хийгээд түүний цаана буй сэдэл, зан байдал (*character*) гэх мэт сэтгэл зүйн шинжтэй хүчин зүйлсийг үл хэрэгсэж, аливаа үйлдлийн зөв эсвэл буруу, зөвшөөрөгдсөн эсвэл үгүйг зөвхөн үр дагаварт оноох болсон аж. Гэхдээ Анскомбе энэ үзлийг гүн гүнзгий байх боломжгүй хэмээгээд гүехэн байдал бол энэ үзлийн мөн чанар мөн хэмээн хатуу дүгнэжээ (Anscombe, 1958). Чухамдаа ийм үзлийг хүлээн авсан хүн, аливаа үйлдлийн зөв эсвэл буруу, зөвшөөрөгдөх эсвэл үгүй эсэхийг тодорхойлохын тулд аливаа үйлдэл ямар үр дүнд хүргэх талаар ямар нэг шалтгаацлын хуульд хандах учиртай болно. Гэтэл ёс зүйд маш олон завсрыйн тохиолдол байдаг бөгөөд бид энэ бүгдийг хэзээ ч бүрэн урьдчилан тооцоолж чадахгүй. Түүний өөрийнх нь татсан жишээг хэрэглэвэл: бид хэн нэг хүнийг хүүхэд асрах үүрэгтэй хэмээн үзсэн үед, тухайн хүн мөнөөх

хүүхдийг асрахаа болихыг хүссэн, эсвэл өөр ямар нэг зорилгод хүрэхийн тулд асрахаа болих хийгээд ямар нэг мундартай (*disgraceful*) зүйл хийхгүй бол шоронд орохоос аргагүй нөхцөл байдалд орсон учраас, мундартай зүйл хийхгүй байж шоронд орсноос болоод мөнөөх хүүхдийг асрахаа болих хоёрын дунд ёс суртахууны үүднээс ямар нэг ялгаа байхгүй болж таарна. Учир нь үр дагаварчлах үзэлтнүүд завсрыйн нөхцөлүүдийг тооцож үздэггүйн зэрэгцээ санаа зорилго хийгээд урьдчилан тооцоолсон үр дагавар хоёрыг зохих ёсоор ялгаж үздэггүй. Ингэснээр тэд аливаа үйлдлийг ёс суртахууны үүднээс авч үнэлэхдээ зөвхөн урьдаас тооцоолж болох үр дүнг л чухалчилдаг. Ингээд үзэх юм бол хүүхдийг аль шалтгаанаар асрахаа болихоос үл хамаараад, тухайн хүүхдийн хувьд асрагчаа алдах нь уршигт үр дагавартай болох учраас үр дагаварчлах үзэлтнүүд энд зохих харьцуулалтыг хийх боломжгүй болдог. Харин Анскомбе бидэнд Аристотель руу эргээд, ёс зүйг хууль гэх ойлгоцод тулгуурлалгүйгээр, хүүхдээс асрамжаа татаж буй дээрх хоёр тохиолдлыг ёс зүйн үүднээс үнэлэх боломж бий хэмээн зааж бас шаардаж байв.

Анскомбе тэнгэрлэг хууль тогтоогчгүйгээр, ёс зүйг хууль гэх үзлийг авч үлдэх оролдлогууд бүтэлгүйтэх талаар онцолсон. Тийм тохиолдолд орчин үеийн ёс суртахууны философичид байгалийн хуульд хандаж болно, эсвэл гэрээний онол, нэг бол тухайн нийгэмдээ тогтсон хэм хэмжээнд тулгуурлаж ёс зүйг хууль гэх үзлийг авч үлдэх талаар ярьж болно. Гэвч Анскомбэгийн үгүйсгэж байгаагаар байгалийн хуулийг дагавал бид нэг хүн нөгөөгөө идэхийг ч хүлээн зөвшөөрч болох учраас энэ нь зөвтгөл болж таарахгүй, нийгмийн хэм хэмжээнд хандвал, хүний мөс чанар (*conscience*) хүний хамгийн бусармаг зүйлсийг хийхэд хүртэл түлхэж болдгийг Батлер үл ойшоосны адилаар, тухайн нийгмийн хэм хэмжээ ч бас хамгийн бусармаг зүйлсийг зөвшөөрч болохыг үл

ойшоосон явдал болно; бас хүний хийх ёстой зүйлсийг гэрээ мэт үзэх нь ч учир дутагдалтай ажээ.

Ёс зүйг хууль гэх үзэлд хандсан шүүмжээс нь үзвэл Анскомбе ёс зүйг бүхэлд нь ямар нэг зарчимтай (Кант шиг өөрөө өөртөө хууль өгөх, эсвэл утилитари үзэлтнүүдийн адилаар ашигт байдлын зарчмыг дагах) дүйцүүлж үзэхээс татгалзсан нь илт харагдана. Гэсэн ч тэр гэмгүй хүнийг тангарагтны шүүхээр оруулж шийтгэх гэх мэт хэрэг явдлыг бид ямагт зүй бус хэмээн тооцох учиртай гэдэг дээр хатуу зогсож байгаагаа тод илэрхийлжээ. Ямар нэг үр дагаврыг тооцох тухайд ярьж, дээрх үйлдлийг зүй бус хэмээн тооцохгүй байж болох эсэх тухайд ярьж буй хүнийг тэр зүгээр л бурангуй оюун санаатай (*corrupt mind*) хэмээгээд маргах хүсэл алга гэдгээ мэдэгдсэн.⁷

Одоо эрхэм чанарын ёс зүй Анскомбэгээс хойш хэрхэн хөгжиж буй талаар тоймлон авч үзье. Эрхэм чанарын ёс зүй нь ёс суртахууны үнэлгээ өгөх явцад хүний зан байдал, сэдэл, сэтгэл хөдлөл зэргийг хамгийн чухал хэмээн төвд тавьдгаараа деонтологи (үүргийг төвд тавигч), утилитари үзэл (үр дагаврыг голчлогч) баримтлалуудаас ялгаатай хэмээн үзэх нь бий. Шинэ үеэр дамжаад, соён гэгээрлийн үеэс эхлэн өрнийн философиин норматив ёс зүйд эрхэм чанараас илүүтэйгээр үүрэг, үр дагавар зэрэг ойлголтууд төвд гарч ирсэн. Орчин үед хүртэл ноёлж ирсэн ёс зүйн эдгээр үзэлд Хьюм, Кант нарын эпистемологийн нөлөө их бий. Хьюмээс улбаатай ‘бол’ гэдгээс ‘ёстой’ гэдгийг гарган авч чадахгүй хэмээх үзэл, оюун ухаан/учир шалтгааныг зөвхөн баримт эсвэл санаануудын харилцан хамааралд үйлчилийн хэмээгээд ёс зүйн асуудалд оюун ухаан/учир шалтгаан (*reason*) үл хамаарна хэмээх үзлийг тойрсон маргаан дунд орчин үеийн ёс суртахууны философи хөгжиж иржээ. Өөрөөр хэлбэл, баримт ба үнэлэмжийн зааг бол орчин

үеийн ёс суртахууны философиин чухал нэг бүрдэл болжээ. Харин Анскомбэгээс эхлээд эрхэм чанарын ёс зүйг сэргээж тавьсан хэмээн тооцогддог сэтгэгчид орчин үеийн ёс суртахууны философиин төвд гарч ирсэн дээрх санааг олон талаас нь шүүмжилсэн билээ. Тэд аливаа үйлдлийг ёс суртахууны үүднээс, алба үүрэг, үр дагавар зэрэг ойлголтод тулгуурлан буруу эсвэл зөв гэж үнэлэхээс; цаашлаад ёс зүйг хууль гэх үзлээс татгалзаж, ёс суртахууны эргэцүүлэлд зан байдал болон сэдэл, санаа зорилгын тухай ойлголтуудыг ашиглахын ач холбогдлыг чухалчилдаг. Өөрөөр хэлбэл бид аливаа үйлдлийг ‘зөв’, ‘буруу’, ‘ёстой’ гэх мэт ойлголтоор үнэлэлгүй, тухайн үйлдлийг хийсэн хүнийг эр зоригтой, шударга, үнэнч эсвэл худалч, хуурмаг, хулчгар гэх мэт үгсээр дамжуулж үнэлэх нь ёс суртахууны шинжилгээнд ач холбогдолтой болохыг тэд учирлаж ирэв.

Гэхдээ өнөө үед эрхэм чанарын ёс зүй гэх ойлголтыг тодорхойлох асуудал багагүй маргаан дагуулж байна. Анскомбэгийн 1958 онд нийтлүүлсэн өгүүлэл нь деонтологийн, бас түүнээс ч илүүтэйгээр Английн ёс суртахууны философичдын дунд өргөн дэлгэрсэн үр дагаварчлах үзлийг (*consequentialism*) шүүмжилж, Аристотельч хандлагаар солих гэсэн оролдлого байв. Гэвч харьцангуй сүүл үеэс эрхэм чанарын ёс зүйг норматив ёс зүйн бусад онолуудтай буюу утилитари болон деонтологи үзэлтэй эсрэгцэх албагүй тухайд тодотгосон бүтээлүүд гарч эхлэв. Жишээ нь Ж.МакДювелл, К.Корсгаард нар Кант, Аристотелийн ёс зүйн үзлийг хооронд нь ойртуулж судалсан байна. Түүнчлэн П.Зингер утилитари үзэлдээ зан байдлыг нэлээд ач холбогдолтой болгон авч үзжээ. М.Нассбаум гэх мэт шинэ-Аристотельч үзэлтнүүд, цаашлаад Р.Харстхаус, Н.Вүүд гэх мэт судлаачид эрхэм чанарын ёс зүй гэх томъёолол үнэхээр утилитари ба Кантч үзэлтэй эсрэгцэх болон бие даасан тусдаа үзэл мөн эсэх тухайд эргэлзэж

⁷Anscombe, G.E.M. (1958) Modern Moral Philosophy, Journal Of Royal Institute of Philosophy, Vol 33. No 124. p.4].

буйгаа илэрхийлсэн нь бий. Түүнчлэн, М.Нассбаум Эрхэм чанарын ёс зүй: Эндүү категори уу? Хэмээх өгүүлэлдээ утилитари хийгээд деонтологич үзэл хоёул зан байдал, эрхэм чанартай холбоотой бөгөөд эрхэм чанарын ёс зүй хэмээх томъёолол нь бие даасан нэг үзэл болон ёс зүйн талбарт гуравдагч үзэл болж чадахгүй гэх санааг дэвшүүлжээ.⁸ Түүнийхээр Кантын үзэлд бардам зан, хүсэл зоригийн хүч, дур хүслээ дасгалжуулах (*training of passions*) зэрэг өнөө цагт эрхэм чанарын ёс зүйд түлхүүр болох ойлголтууд ач холбогдолтой байдаг. Харин эдгээрийг тодорхой цаг үед байсан ёс суртахууны философи л үл тоож ирснээс биш, Кант өөрөө бол хэрэгсээгүй юм биш; иймд Кантын ёс зүйн үзлийг үүрэг, зарчим зэргээр л хэт хөөцөлдсөн мэт дүгнэх үндэслэл бидэнд байхгүй аж. Мөн Сижвик, Бентам, Милл зэрэг утилитари үзэлтнүүдийн хувьд ч санаа зорилго (*intention*), сэдэл зэрэг эрхэм чанарын ёс зүйн гол цөм гэгддэг ойлголтууд багтаж ирснийг, Сижвикийн эрхэм чанаруудын ангилал ч бас түүний ёс суртахууны философийн чухал бүрдэл байсныг онцолжээ. Хэрэв энэ хоёр онол өөртөө эрхэм чанарын ёс зүйн шинжийг ихээр агуулж ирсэн, харин философичид тодорхой цаг үеийн онцлогоос болоод тэдгээрийг үл хайхарч ирсэн бол эрхэм чанарын ёс зүй гэх томъёолол бие даасан онолыг тэмдэглэх эсэх нь асуудалтайг Нассбаум онцолжээ.

Иймд бид Эрхэм Чанарын ёс зүйг анх Анскомбэгийн дэвшүүлсэн шиг, бас өнөө үеийн зарим гарын авлага, нэвтэрхий толь бичгүүдэд бичиж байгаачлан, утилитари үзэл ба деонтологитой хатуу эсрэгцүүлж тавих биш харин орчин үеийн гэх томъёолол дор буй норматив ёс зүйд байсан эпистемологи, хийгээд метафизикийн тухайлсан арга зүйд хандсан шүүмж болох үүднээс авч үзэх нь илүү

зохильтой талаарх санааг дэвшүүлсэн судлаачид бас бий.⁹ Хэрэв ийн үзвэл бид Анскомбэгээс хойших шинэ-Аристотельч үзэлтнүүд ёс зүйг хууль гэхээс татгалзсан, зан байдал, сэдэл, санаа зорилго гэх мэт сэтгэл зүйн хүчин зүйлсийн ач холбогдлыг ёс зүйн асуудлын төвд тавьж, эсвэл зохих ач холбогдолтойг хүлээн зөвшөөрч анхаарал хандуулан авч үзсэн, сэтгэл хөдлөл ба оюун ухаан хоёрыг, цаашлаад баримт үнэлэмжийг эсрэгцүүлэн зааглахаас татгалзсан зэргээр нь еренхийлөн үзэж болох юм. Өнөөдөр эрхэм чанарын ёс зүй зөвхөн Аристотельч үзлээр хязгаарлагдалгүй, төрөл бүрийн хэлбэртэйгээр хөгжиж байна.

Ном Зүй

- Angle, S., Slote, M. (2013) *Virtue Ethics and Confucianism*, Routledge
- Anscombe, G.E.M. (1958) Modern Moral Philosophy, Journal Of Royal Institute of Philosophy, Vol 33. No 124: 1-19
- Besser, L.L., Slote, M. (2015) *Routledge Companion to Virtue Ethics*, Routledge
- Hursthouse, R. (2002) *On Virtue Ethics*, Oxford University Press: 4-9
- Nussbaum, M. (2001) M. Nussbaum (1999). Virtue Ethics: A Misleading Category? *The Journal of Ethics*, 3 (3): 163-201
- Wood, N. (2020) *Virtue Rediscovered: Deontology, Consequentialism, and Virtue Ethics in the Contemporary Moral Landscape*, Lexington Books: 11-17

Abstract: Elizabeth Anscombe's paper called *Modern Moral Philosophy* has played an important role in reviving virtue ethics in modern times. In this article, we clarify how Anscombe criticized modern moral philosophy, particularly consequentialism, and discuss virtue ethics are viewed today.

⁸ M. Nussbaum (1999). *Virtue Ethics: A Misleading Category?* *The Journal of Ethics*, 3 (3), pp. 163-201

⁹ Wood. N. (2020) *Virtues Rediscovered: Deontology, Consequentialism and Virtue Ethics in the Contemporary Moral Landscape*. Lexington Books; Hursthouse. R. (1999) *On Virtue Ethics*. Oxford University Press зэргийт үзүүлүү. Харстхус уг бүтээлдээ Аристотелийг Миллтэй ойртуулах ажил хараахан хийгдээгүй байгаа ч, ирээдүйд хийгдэнэ гэдгийг угтгысгэх арга ердөөс байхгүйг тэмдэглэсэн бий.